



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 11/168

Цагаан-Уул сум

Г Хяналт тавих комисс томилох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Гал түймэр унтраах аврах 73 дугаар ангид агааржуулалтын хоолой хийх ажилд хяналт тавих комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ахлагч: А.Энхбаяр (Сумын хэсгийн төлөөлөгч)

Гишүүн : Ж.Бадрал (Архив, бичиг хэргийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: П.Отгонбат (Хөдөлмөр, халамж үйлчилгээний мэргэжилтэн)

2. Ажлын даалгавар, зураг төсвийн дагуу дээрх ажилд хяналт тавьж тэмдэглэл хөтлөж, акт үйлдэж ажиллахыг хяналт тавих комисс (А.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ ДАРГА



Н.АЛТАНБААТАР